



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 06 сарын 29 өдөр
хот

Төрийн ордон. Улаанбаатар

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД

ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аялал жуулчлалын тухай хуулийн 16 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай дараахь заалт, хэсэг нэмсүгэй:

1/ 16 зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт:

“16.1.8. аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх, Монгол орныг гадаад, дотоодод сурталчлах үйл ажиллагааг санхүүжүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх;”.

2/ 16 зүйлийн 2 дахь хэсэг:

“16.2.Энэ хуулийн 16.1.8-д заасан үйл ажиллагааг гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаадын болон дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив, тусламж, хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрээс санхүүжүүлж болно.”.

2 дугаар зүйл.Аялал жуулчлалын тухай хуулийн 16.1.8-16.1.14 дэх заалтын дугаарыг “16.1.9-16.1.15” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Аялал жуулчлалын тухай хуулийн 14.1.4 дэх заалт, Тавдугаар бүлгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН

ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ